



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 4.1.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цацраг идэвхт ашигт малтмалын салбарын хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, батлагдсан нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан, буцаасан болон Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн мэдээллийн санд "цөмийн энергийн талбай" гэж бүртгэгдсэн талбайнуудаас цацраг идэвхт ашигт малтмал хайх, ашиглах боломжтой талбай ялгахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав), Ашигт малтмал, газрын тосны газар (Д.Оюунцэцэг), Үндэсний геологийн алба (Н.Мөнхбилэг), "Мон-Атом" ХХК (Д.Далайжаргал) хамтран судалж шийдвэрлэхийг чиглэл болгосугай.

2. Цөмийн энергийн комиссын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хэрэгжилт, энэ тогтоолоор өгсөн чиглэлийн биелэлтийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Цөмийн энергийн комисст танилцуулахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав), Ашигт малтмал, газрын тосны газар (Д.Оюунцэцэг), Үндэсний геологийн алба (Н.Мөнхбилэг)-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

ДАРГА



Г.ДАМДИННЯМ